



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн
чанар тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2026 оны “Боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг тогтоох үйл ажиллагааг холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төв (Э.Цэрэнцоодол)-д үүрэг болгосугай.


2.Энэхүү тушаалын 1-д заасан үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хавсралтаар баталж, батлагдсан 393,597,000 (гурван зуун ерэн гурван сая таван зуун ерэн долоон мянга) төгрөгийг Боловсролын сайдын 2026 оны “Хөтөлбөр, арга хэмжээний 2026 оны жагсаалт шинэчлэн батлах тухай” А/28 дугаар тушаалын хавсралтын 3.6-д заасан зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Ням-Очир)-д зөвшөөрсүгэй.

3.Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбийг 2026 оны гуравдугаар улиралд, чансаа болон хөтөлбөрийн чанарын үнэлгээний дүнг 2026 оны дөрөвдүгээр улиралд тус тус олон нийтэд мэдээлж, үр дүнг тухай бүр танилцуулахыг Боловсролын үнэлгээний төв (Э.Цэрэнцоодол)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсролын сайдын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай” А/574 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.

САЙД



П.ЭНХ-АМГАЛАН

1420010127

Боловсролын сайдын 2026 оны
05 дугаар сарын 01-ний өдрийн
А/39 дугаар тушаалын хавсралт



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДЭСНИЙ ЭРЭМБЭ,
ЧАНСАА, ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫГ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Арга хэмжээний нэр	Хугацаа	Хүрэх үр дүн	Төсөв (мян. төгрөг)
1.	Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг тогтоох үйл ажиллагааны бэлтгэл ажлыг зохион байгуулах	2026.05	Арга хэмжээний зохион байгуулалт хийгдэж, төлөвлөгөө батлагдсан байна.	-
2.	Олон улсын мэргэжлийн байгууллагын зөвлөх үйлчилгээ авах	2026.05- 2026.09	Олон улсын байгууллагатай гэрээ байгуулж, зөвлөх үйлчилгээний нөхцөл, хуваарийг гаргаж, шалгуур үзүүлэлт, аргачлалын зөвлөгөө авсан байна.	108,750
2.	Үнэлгээний аргачлал боловсруулах, батлуулах А.Эрэмбэ тогтоох Б.Чансаа тогтоох В.Хөтөлбөрийн чанарын үнэлгээ хийх	2026.05- 2026.12	Монголын дээд боловсролын сургалтын байгууллагуудын онцлог, олон улсын нийтлэг зарчимд нийцсэн үнэлгээний аргачлал боловсруулагдаж, батлагдсан байна.	83,552
4.	ДБСБ-ын дата өгөгдлийг боловсруулах, үр дүнг олон нийтэд нээлттэй харагдах интерактив цахим системийг хөгжүүлэх, сайжруулах	2026.05- 2026.12	Батлагдсан үнэлгээний аргачлалын дагуу өгөгдөл боловсруулах систем, үр дүнг олон нийтэд нээлттэй, интерактив байдлаар харуулах системийг хөгжүүлсэн байна.	175,188
5.	Үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг тогтоож, үр дүнг зарлах, тайлан гаргах	2026.08- 2026.12	Үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарын үнэлгээний дүнг олон нийтэд нээлттэй мэдээлж, үнэлгээний тайланг боловсруулсан байна.	26,107
НИЙТ 393,597,000 ТӨГРӨГ				

---о0о---